



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 23 өдөр

Дугаар А/840

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 9 дүгээр сарын 23-ны 61 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Монгол Улсын Засгийн газрын “Цахим засаглал” үндэсний хөтөлбөр, “Ховд аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт заасны дагуу Ерөнхий боловсролын сургуулиудад сүүлийн үеийн цахим технологи ашиглан сургалт явуулах орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор ухаалаг дэлгэцийг худалдан авах байгууллага, зардлын дүнг хавсралтаар баталсугай.

2. Тус арга хэмжээнд зарцуулах зардлыг төсвийн байгууллагуудын хэмнэгдсэн төсвөөр зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ -д зөвшөөрсүгэй.

3. Ухаалаг дэлгэц худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад холбогдох заавар журмын дагуу худалдан авалтыг зохион байгуулж хэрэгжүүлэхийг төсвийн захирагч нарт үүрэг болгосугай.


4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Г. Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б. ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны
12 дугаар сарын 23-ны өдрийн
А/840 дүгээр захирамжийн хавсралт



УХААЛАГ ДЭЛГЭЦ АВАХ ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЖАГСААЛТ

№	Байгууллагын нэрс	Хэмжих нэгж	Тоо ширхэг	/Мянган төгрөгөөр/	
				Нэг бүрийн үнэ	Нийт
1	Алтай	ш	1	13000,0	13000,0
2	Булган сумын I сургууль	ш	1	13000,0	13000,0
3	Булган сумын II сургууль	ш	1	13000,0	13000,0
4	Буянт	ш	1	13000,0	13000,0
5	Дарви	ш	1	13000,0	13000,0
6	Дуут	ш	1	13000,0	13000,0
7	Дөргөн	ш	1	13000,0	13000,0
8	Зэрэг	ш	1	13000,0	13000,0
9	Манхан	ш	1	13000,0	13000,0
10	Мөст	ш	1	13000,0	13000,0
11	Мөнххайрхан	ш	1	13000,0	13000,0
12	Мянгад	ш	1	13000,0	13000,0
13	Үенч	ш	1	13000,0	13000,0
14	Ховд	ш	1	13000,0	13000,0
15	Чандмань	ш	1	13000,0	13000,0
16	Эрдэнэбүрэн	ш	1	13000,0	13000,0
17	Жаргалант Цаст-Алтай	ш	1	13000,0	13000,0
18	Жаргалант II сургууль	ш	1	13000,0	13000,0
19	Жаргалант Прогресс	ш	1	13000,0	13000,0
20	Жаргалант VII сургууль	ш	1	13000,0	13000,0
НИЙТ					260 000,0

-оОо-